

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ХХБ	Худалдаа Хөгжлийн банк



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН  
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.БАТБАЯР ТАНАА

2020.04.24 № 06/1313  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Б.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн нэгжийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Х.Дорж, ахлах аудитор Т.Сугарсүрэн, аудиторын туслах П.Ганчимэг, Т.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1/157а дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилт авах боломж болон бизнесийн тогтвортой байдлыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлт, төрөлжүүлэлт болон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2016 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу Азийн хөгжлийн банк нь Монгол Улсад дээрх зээлийн хэлэлцээрт тусгагдсан 60.0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийг барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын зээлийн батлан даалтад олгохоор Зээлийн батлан даалтын сан нь энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Уг төсөл нь 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжих бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 12.0 сая доллар буюу 32,792.6 сая төгрөгийн төслийн санхүүжилт болох хөнгөлөлттэй зээлийг Азийн хөгжлийн банкнаас хүлээн авсан. Төслийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд Азийн хөгжлийн банкны шалгуурыг хангасан арилжааны банкинд нийт 18,972.1 сая төгрөгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын зээлийн батлан даалт гаргаснаас гэрээний дагуу 90 хувь нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс, 10 хувь нь Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрээс тус тус санхүүжигдсэн байна.

Төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, болон дараахь журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын хавсралт “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интер Актив Би Ай ХХК-ийн “Даймонд” программ хангамж ашигладаг байна.

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын буюу нийт зээлийн ашиглалтыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтийн дүн 17,074,924.8 мянган төгрөгөөс тооцон 170,749.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 170,749.2 мянган төгрөгөөр тооцсон нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд зээлээр олгогдож буй санхүүжилтийг үр ашигтай, хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулаагүй байх эрсдэл үүсэх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,300,100.6 мянган төгрөгөөр буюу 55 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,809,153.0	43,109,253.6	15,300,100.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>27,809,153.0</b>	<b>43,109,253.6</b>	<b>15,300,100.6</b>
Бусад өглөг	-	123.3	123.3
Хуримтлагдсан үр дүн	27,809,153.0	43,109,130.3	15,299,977.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>27,809,153.0</b>	<b>43,109,253.6</b>	<b>15,300,100.6</b>

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт орсон нь Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй холбоотой юм.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрт зориулан 17,580,474.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 17,074,924.8 мянган төгрөг буюу 97 хувийн гүйцэтгэлтэй байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 1 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

## **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

“Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл” -ийн хэрэгжүүлэгч нэгж болох Зээлийн батлан даалтын сан нь 2012 онд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагааны чиглэлтэйгээр байгуулагдсан хуулийн этгээд юм.

АХБ- наас санхүүжиж буй бүх ажил гүйлгээ нь Зээлийн батлан даалтын сангийн НББ-н ажил гүйлгээнд орж, санхүүгийн тайланд нэгтгэгдэн тайлагнагддаг. Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн тайланд жил бүр Үндэсний Аудитын Газраас санхүүгийн тайлангийн аудит хийж баталгаажуулдаг.

Иймд тус Азийн хөгжлийн банкнаас хэрэгжиж буй төслийн төгрөгөөр илэрхийлэгдэх санхүүгийн тайланг Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн тайлангаас тусад нь тайлагнах шаардлагагүй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Зээлийн батлан даалтын сан нь Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан хугацаанд нь ил тод мэдээлж байршуулсан байна.

Зээлийн батлан даалтын сан нь тайлант онд шилэн дансандаа төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт тендер, худалдан авалт, бусад гэсэн нийт 17 мэдээлэл байршуулсан ба үүнээс 8 мэдээллийг хугацаандаа, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 67,200.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн



гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн-ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний Үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>27,809,152,975.03</b>	<b>43,109,253,588.33</b>
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	27,809,152,975.03	43,109,253,588.33
Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	-	-
<b>АВЛАГА</b>	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
Бусад авлага	-	-
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,809,152,975.03</b>	<b>43,109,253,588.33</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
Барилга, байгууламж	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Бусад үндсэн хөрөнгө	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	-
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,809,152,975.03</b>	<b>43,109,253,588.33</b>
Богино хугацаат өр төлбөр	-	-
Бусад өглөг	-	123,287.67
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>123,287.67</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>123,287.67</b>
Засгийн газрын хувь оролцоо	-	-
Хуримтлагдсан үр дүн	27,809,152,975.03	43,109,130,300.66
Өмнөх үеийн үр дүн	11,925,006,105.65	27,205,721,340.00
Тайлант үеийн үр дүн	15,884,146,869.38	15,903,408,960.66
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,809,152,975.03</b>	<b>43,109,130,300.66</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,809,152,975.03</b>	<b>43,109,253,588.33</b>

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>47,982,619,379.38</b>	<b>32,962,668,931.98</b>
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>44,189,975,450.00</b>	<b>32,962,448,655.42</b>
Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих	44,189,975,450.00	32,792,585,345.60
Хүүгийн орлого / тусгай данс /	-	169,863,309.82
Улсын төсвөөс	-	-
Орон нутгийн төсвөөс	-	-
<b>Бараа үйлчилгээний орлого</b>	<b>3,792,643,929.38</b>	<b>220,276.56</b>
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	650,045,529.38	-
Бусад орлого	3,142,598,400.00	220,276.56
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>47,982,619,379.38</b>	<b>32,962,668,931.98</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
Цалин	-	-
Тогтмол зардал	-	-
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>3,142,598,400.00</b>	<b>-</b>
Бичиг хэргийн материал	-	-
Гадаад томилолтын зардал	-	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	3,142,598,400.00	-
Хөтөлбөр арга хэмжээний зардал	-	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3,142,598,400.00</b>	<b>-</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>44,840,020,979.38</b>	<b>32,962,668,931.98</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	-	15,707,124.10
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>-</b>	<b>15,707,124.10</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		
Дамжуулан зээлдүүлэх зээл	28,955,874,110.00	17,074,967,095.42
Хөрөнгө худалдсаны гарз	-	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (IV)</b>	<b>28,955,874,110.00</b>	<b>17,074,967,095.42</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>15,884,146,869.38</b>	<b>15,903,408,960.66</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>56,114,981,555.65</b>	<b>36,513,048,588.67</b>
Улсын төсвөөс	-	-
Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих	44,189,975,450.00	32,792,585,345.60
Хүүгийн орлого	-	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,925,006,105.65	3,720,463,243.07
<b>Бараа үйлчилгээний орлого</b>	<b>3,142,598,400.00</b>	-
Бусад орлого	3,142,598,400.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>59,257,579,955.68</b>	<b>36,513,048,588.67</b>
Цалин	-	-
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>3,142,598,400.00</b>	<b>4,153,688,004.05</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	3,142,598,400.00	4,133,872,467.79
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>19,815,536.26</b>
Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,815,536.26
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>3,142,598,400.00</b>	<b>4,153,730,258.67</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>56,114,981,555.65</b>	<b>32,359,360,584.62</b>
<b>Хөрөнгийн орлого</b>	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	650,045,529.38	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>650,045,529.38</b>	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)</b>	-	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>650,045,529.38</b>	-
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	28,955,874,110.00	17,074,967,095.42
Валютын ханшийн зөрүүний олз	-	15,707,124.10
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)</b>	<b>(28,955,874,110.00)</b>	<b>(17,059,259,971.32)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)</b>	27,809,152,975.03	15,300,100,613.30
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	27,809,152,975.03
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	27,809,152,975.03	43,109,253,588.33

#### 4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	<b>27,809,152,975.03</b>	<b>27,809,152,975.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(603,431,635.03)	(603,431,635.03)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>27,205,721,340.00</b>	<b>27,205,721,340.00</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	15,903,408,960.66	15,903,408,960.66
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	<b>43,109,130,300.66</b>	<b>43,109,130,300.66</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	17,580,474,900.00	17,074,967,095.42	505,507,804.58	97
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	-	-	
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	-	-	
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	-	-	
Үндсэн цалин	-	-	-	
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	-	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-	-	
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	-	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	17,580,474,900.00	17,074,967,095.42	505,507,804.58	97
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	-	-	-	
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	17,580,474,900.00	17,074,967,095.42	505,507,804.58	97
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	17,580,474,900.00	32,792,585,345.60	(15,212,110,445.60)	186
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	
Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	17,580,474,900.00	32,792,585,345.60	(15,212,110,445.60)	186
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	17,580,474,900.00	32,792,585,345.60	(15,212,110,445.60)	186
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	
Хандив тусламж /дотоод/	-	-	-	
Хандив тусламж /гадаад/	-	-	-	
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	-	
Тусгай дансны хүүгийн орлого	-	-	-	
Хүүгийн орлого	-	-	-	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	27,809,152,975.03	27,809,152,975.03	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	43,109,253,588.33	43,109,253,588.33	

## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 rows.